

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 14-ны өдөр

Дугаар...

БА-053/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар 720 (долоон зуун хорь) суудал бүхий хүчин чадалтай сургуулийн зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/10/14 огноо, 0001416 дугаар, БА32024/0687,

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: 012-2020-NC,

2.3. Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар оноосон нэр, 9014001040 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5369622 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Арцатын аманд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны нэгдсэн цогцолбор барилга "Б" блок 5 давхар 510 тоот, 11311632 холбоо барих утас;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Дарцагт ноёд групп ХХК оноосон нэр, 9011539044 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5945607 регистрийн дугаар, БУ11-136/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 13 дугаар хороо, 3-р хороолол, Хасбаатар 20-7 тоот, 91030427 холбоо барих утас;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Ньюкон ХХК оноосон нэр, 9011189008 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2561697 регистрийн дугаар, 3Т19-155/18 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо, Стадион оргил, Нийслэл хүрээ өргөн чөлөө гудамж, Парк гарден плаза, 703 тоот, 75074411 холбоо барих утас;

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Нийслэлийн Боловсролын газар оноосон нэр, 000049559 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9077065 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Багшийн хөгжлийн ордон, 5 давхар, 70113039 холбоо барих утас, city.edu.mn цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар 720 (долоон зуун хорь) суудал бүхий хүчин чадалтай сургуулийн зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

ХЯНАЛТ ШИ
ГАЗ

Барилга байгууламж
орлуулах

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 7 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар 720 (долоон зуун хорь) суудал бүхий хүчин чадалтай сургуулийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо,
Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газрын захиалгатай, зорьтой 3 давхар,
720 (долоон зуун хорь) суудалтай сургуулийн барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газрын
Барилга захиалагчийн хэлтсийн дарга



(Б.Ганзориг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



СҮХБААТАР ДҮҮРГИЙН 12 ДУГААР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 3 ДАВХАР, 720 (ДОЛООН
ЗУУН ХОРЬ) СУУДАЛТАЙ СУРГУУЛИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зорьтой 3 давхар, 720 (долоон зуун хорь) суудалтай сургуулийн барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1-р давхрын танхимд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 10:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:30 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг**
2. Комиссын нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Ахлах инженер **Б.Намсрайжав**
3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Ж.Жүгдэрмаа**
4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**
5. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн Стандарт, хяналтын хэлтэс, Газрын тос хийн хяналтын улсын байцаагч **Ч.Ганхуяг**
6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Техник хяналтын инженер **П.Сүхбаатар**
7. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газрын Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Ц.Дагвадорж**
8. Ус сувгийн удирдах газар Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Б.Жалбалцанжид**
9. Нийслэлийн Онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, Хошууч **Б.Дөл-Эрдэнэ**
10. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч **Я.Чулуун**
11. Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

хэлтсийн инженер	Г.Уртнасан
12. Нийслэлийн боловсролын газар, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн ЕБС, цэцэрлэгийн барилга, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн	Д.Ирмүүнзаяа
13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан	Б.Болормаа
14. Ньюкон ХХК-ийн инженер	С.Амаржаргал
15. Дарцагт ноёд групп ХХК-ийн захирал	Д.Ганзориг

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зорьтой 3 давхар, 720 (долоон зуун хорь) суудалтай сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Ж.Жүгдэрмаа:**

- Сургуулийн барилгын давхар бүрд бетоны лабораторийн шинжилгээний дүнг хянуулах;
- Журналд бетон цутгасан үеийн тэмдэглэл, ханган нийлүүлэгч тодруулж бичих, өмнө өгсөн (зохиогч, захиалагчийн) үүргийн биелэлт хүлээн авсан байдлыг гүйцээж хянуулах;
- Захиалагч, зохиогчийн дүгнэлтийг дүрмийн дагуу дахин боловсруулж зураг төсөл, чанарын шаардлагад хяналт тавьж ажиллаж биелсэн талаар мөн хөрсний ус илэрсэн бол хийцийг хэрхэн хамгаалсан талаар тодорхой бичиж хянуулах;
- Нэгдүгээр давхрын шалны хулдаасны наалтыг дахин шалгаж, уулзварын хөндийрсөн хэсгийг засварлаж фото зураг ирүүлэх;
- Зоорийн давхрын шалны өнгөлгөө гүйцээх, дээвэрт гарах шат, шалнаас тааз хүртэл шилэн ханын хаалт хамгаалалт, ашиглалтын аюулгүй байдлыг хангуулсан гүйцэтгэл фото зураг ирүүлэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа:**

ХЯ
Барилга

- Дулааны худаг-1-ийн дулаалгыг бүрэн гүйцэд хийж, өнгийн туузаар ороож, худгийг цэвэрлэх;
- Давхар бүрийн ариун цэврийн өрөөний агааржуулалтыг бүрэн угсарч дуусгах (сэнс суурилуулах) ;
- Спорт заалны АС-н өгөх хэсгийг зурагт тусгагдсаны дагуу дулаалах, решётка суурилуулах;
- Зоорийн давхрын узелийн өрөөг хаягжуулах;
- Анги доор байгаа халаалтын коллекторыг цэвэрлэж, хайрцаглах;
- 1 давхрын хоолны газрын агааржуулалтыг бүрэн ажилагаанд оруулж баталгаа албан тоот ирүүлэх;
- 1 давхрын хоолны газрын халаалтын шугам сүлжээг далдлах;
- Гадна дулаан, цэвэр усан хангамжийн системийг угсарсан, сорилтоор шалгасан актыг бүрэн баталгаажуулах;
- Барилгын салхивчийн систем угсарсан, сорилтоор шалгасан актыг бүрэн баталгаажуулах;
- Дотор халуун, хүйтэн усан хангамж угсарсан ил далд ажлын актыг бүрэн баталгаажуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер **П.Сүхбаатар:**

- Цахилгааны өрөөний хаалганд хаяг, плакат хийх;
- АВР-ын болон бусад тоолуурыг лацдуулах;
- Цахилгааны самбаруудад хаяг, схем, бирк хийх;
- Халуун усны, халаалтын, нэмэлт усны насосуудыг газардуулгад холбох;
- Узелийн насосуудын цахилгааны самбарт газардуулга хийх;
- Зоорийн давхрын цахилгааны самбарын зургыг батлуулж үзүүлэх;
- Газардуулгын протокол үзүүлэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн Стандарт, хяналтын хэлтэс, Газрын тос хийн хяналтын улсын байцаагч **Ч.Ганхуяг:**

- Аянга зайлуулагч газардуулгатай байгууламжтай эсэргүүцлийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх (ГТБТ Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.4);
- Мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг атестачлагдсан (хийн аюулгүй ажиллагааны дүрэм 1.2.1 заалт) ;
- Хийн хадгалах тоног төхөөрөмжийн техник ашиглалт аюулгүй ажиллагаа хариуцагчийг тушаалаар томилсон байх (даралтат савыг аюулгүй ашиглах дүрмийн 7.1.1 заалт) ;
- Галын аюулгүй байдалд дүгнэлт гаргуулсан (ГТБТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 заалт);
- Хориглох, анхааруулах, заах тэмдгүүдийг байрлуулах (даралтат савны хамгаалалт саравчинд);

- Гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр холбогдсон (хийн аюулгүй ажиллагааны дүрмийн 3.6.9 заалт);
- Ашиглалтыг хэн хариуцсан бэ, гэрээ хийх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газрын Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Ц.Дагвадорж**:

- Дотор холбоо дохиоллын актуудыг бүрэн баталгаажуулах
- Гадна холбооны угсралтын ажлын 2 ширхэг бетонон баганыг дугаарлах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн инженер **Б.Жалбалцанжид**:

- Гадна цэвэр, бохир усны ажлын зургийн өөрчлөлтийн тайлбар бичиг хийх;
- Бохир усны гаргалгаа худаг болон холбогдсон худгуудын ажлын талбай хийцийг янзлах, тагийг стандалт болгох;
- Бохир усны шугамд үл буцах клапан суурилуулах;
- Гаднаас орж ирсэн цэвэр усны шугам шалан доогуур явсан хэсгийг ил болгох эсвэл сувагт оруулах;
- Гадна цэвэр усны худгийн усыг соруулж цэвэрлэх;
- Гадна цэвэр усны шугамыг хэрхэн яаж хөлдөлтөөс хамгаалсан эсэхийг фото зураг, албан бичгээр өгөх;
- Нөөцийн савыг халдваргүйжүүлэлт хийлгэсэн акт болон усны шинжилгээний дүгнэлтийг шалгуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Нийслэлийн Онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, Хошууч **Б.Дөл-Эрдэнэ**:

- Аврах, зам гарц, хаалга чөлөөтэй онгойлгодог болгох
- Галын дохиоллын мэдрэгч, станцыг бүрэн ажиллуулах
- Зоорийн давхрын өрөөний өөрчлөлтийн талаар автор, гүйцэтгэгч, захиалагч нар дүгнэлт, албан бичиг гарган өгөх
- Гал унтраах анхан шатны багаж, зэмсэглэмж, гал унтраагуур байрлуулах
- Зургийн дагуу хаалга, цонхнуудыг хийж гүйцэтгэх (өрөө, тасалгаа, анги, танхимууд)
- Шатны хонгилуудын цонхны өмнө хаалт, хашлага хийж гүйцэтгэх
- Аврах зам, гарцын тэмдэг тэмдэглэгээг бүрэн гүйцэд хийх
- Гадна дулаалгын материалын шинжилгээний дүгнэлт нөхөж үзүүлэх
- Гал түймэр унтраах даралтын хоолой техникийн шаардлагын дагуу тотго холболтыг хийж гүйцэтгэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч **Я.Чулуун:**

- Архивд зураг төслийн баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримтаа бүрэн бүрдэлтэйгээр эх хувийг хүлээлгэн өгөх
- Баримт бичгийг архивын заавар журмын дагуу цэгцлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **Г.Уртнасан:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан нормачлалын сангийн төлбөр төлөх;
- Шилэн хаалгануудад наалт, анхааруулга, тэмдэглэгээ нааж өгөх;
- Шатны эргэх талбай шилэн фасаданд хамгаалалт хийх;
- Температурын заадас хэсгээр чигжээс хийж засварлах;
- Дээвэррүү гаргах шат бариул хийх;
- Гадна фасад чигжээс хөндийрсөн хэсэгт дахиж хийх;
- Дээврийн хар цаасан хучлага хөндийрсөн, дулааны улиралд хийх баталгаа албан бичиг гаргаж ирүүлэх, хувийг ашиглагч байгууллагад өгөх;
- Зоорийн давхрын бетон шалны өнөлгөө хийх;
- Гадна тохижилт батлагдсан ЕТ-ний дагуу гүйцэтгэх баталгаа албан бичиг ирүүлэх;
- 1 дүгээр давхрын налуу зам бариул хийх;
- Ариун цэврийн өрөөнд хаалт, тусгаарлах кабин хийх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Болормаа:**

- Авто машины зогсоолоос явган хүний зам хүртэл налуулалт хийж өгөх
- Давхар бүрийн ариун цэврийн өрөөнүүдэд ХБИ зориулсан тоноглол хийх
- 1 давхрын шатны хажуугийн налуулалтыг стандартын дагуу хийх
- Спорт заалны босгыг налуулалттай болгох буюу стандартын дагуу хийх
- Спорт заалны хажуугийн ариун цэврийн өрөөнд тоноглол хийж, шүршүүрт хальтарч унахаас сэргийлж бариул хийх
- Гадна авто машины зогсоолд ХБИ зориулсан босоо болон хэвтээ тэмдэглэгээ хийх
- Гадна налуу замыг стандартын дагуу 2 бариултай хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Нийслэлийн боловсролын газар, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн ЕБС, цэцэрлэгийн барилга, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн **Д.Ирмүүнзаяа:**

- Давхруудын ариун цэврийн өрөөний хаалт кабин хийх
- Нийт босоо, хэвтээ халаалтын шугам бэхэлгээ хийх

- Дотор засал сайжруулах, хаалганы амалгаа, техникийн өрөөний шал, холбоо, цахилгааны өрөөний хяналтын лоок хийх, 2,3 дугаар давхрын хаалга босгогүй болгох
- Шилэн хаалга солих, шаардлагатайг хамгаалалтын хуулга наах
- Спорт заалны цонх хамгаалах, тоноглол, сагсны шийт хийх
- Гал тогооны өрөөнд АСС-ын зонт, 3-н дамжлагат угаалтуур тос баригч хаалт хийх, агуулахад ААС гаргах
- Шатны эргэлтийн хэсгийн цонх хамгаалах
- Урлаг зааланд тайз хийх (зургийн дагуу)
- 3 давхарт шат хамгаалах, налуу зам бариул хийх
- Анги, АЦӨ-ний шалны түвшин нэг болгон засах
- Гадна тохижилт дуусгаж, хашаа засах
- Газ зааварчилгаа өгч, дүгнэлт гаргуулах, газ үнэртэж байна
- Бичиг баримт зураг төсөл нэг хувь хүлээлгэн өгч хувийн хэрэг үүсгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Барилга захиалагчийн хэлтсийн ахлах инженер **Б.Намсрайжав:**

- Ариун цэврийн өрөөнүүдэд таславч хийх;
- Урлаг зааланд тайз хийх
- Барилгын эргэн тойронд хаявчийг засаж сайжруулах
- Шилэн хаалга, хананд тэмдэг тэмдэглэгээ хийх
- Дотор заслыг зарим газарт засаж сайжруулах
- Заалны утааны мэдрэгчийг лазер мэдрэгчээр солих
- Төгсгөлийн төхөөрөмжүүдийг зурагт тусгасны дагуу угсрах
- Бүх самбаруудад хом, бирк хийх
- Гадна газны барилгад самбарын газардуулга хийх, насосууд газардуулга холбох
- Ариун цэврийн өрөөнүүдэд суултуур соролт муу байгааг шалгаж арга хэмжээ авч ажиллах
- Гадна тохижилт, ногоон байгууламжийг дулааны улиралд гүйцэтгэх баталгаа гаргаж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Ньюкон ХХК-ийн инженер **С.Амаржаргал:**

- Барилгын цэвэрлэгээг үргэлжлүүлэн хийх;
- Цэвэр усны оруулга шугамыг шаланд угсрагдахын өмнөх үзлэг шалгалтын дагуу зөвшилцсөнөөр ил явуулах, гүйцэтгэлийн зургаар баталгаажуулах;
- Услах кран угсрах;
- Гадна цэвэр усны худагт галын гидрант угсрах;
- Спорт заалны душ болон усанд орох хэсгийн өрөөний унтраалгад зориулж гаргасан цахилгааны утсыг цахилгаан хангамжаас бүрэн таслах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Дарцагт ноёд групп ХХК-ийн захирал **Д.Ганзориг**:

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг**:

- БНД-11-04-16 дагуу зохиогч дүгнэлт шинэчилж ирүүлэх;
- БТХ-ийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгад чанарын баталгаа албан бичгээр ирүүлэх;
- Зохиогч анги танхимын хаалга, босго, ариун цэврийн өрөөний хүчин чадал, хүртээмжийн талаар тайлбар ирүүлэх;
- Спорт заалны цонх, халаах хэрэгсэлд хамгаалалт хийх;
- Барилгын хаяавч, ногоон байгууламжийн ажлыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх хугацаа заасан баталгаа албан бичиг ирүүлэх;

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зорьтой 3 давхар, 720 (долоон зуун хорь) суудалтай сургуулийн барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын,
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч


..... (Б.Батчимэг)

Тэмдэглэл хөтөлсөн:

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар,
барилга захиалагчийн хэлтсийн дарга


..... (Б.Ганзориг)